



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/33

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн 2 иргэний гаргасан хүсэлтийн дагуу 0.2441га (2441м²) газрын газар эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар хугацааг сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.


3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/18 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАХ
ИРГЭДИЙН ЖАГСАЛТ

№	Иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын талбайн хэмжээ (м ²)	Газрын байршил	Газрын зориулалт	Газар эзэмших хугацаа	Хүчингүй болгож буй шийдвэрийн огноо
1	Шандаас овгийн Доржтүрэв Гансүх (РЭ88062817)	6712017836	1941	13-р баг Хар замын урд Худгийн зүүн талд	Төмс, хүнсний ногооны усаалтаатай тариалан	30	Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/209 дүгээр захирамжийн хавсралтын 6 дэх заалтын 8 дахь багана
2	Хамар овгийн Шаравжамц Амгаланбаатар (РЮ00212451)	6712008100	500	6-р баг Од-2 210 тоот	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	20	Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн А/38 дугаар захирамжийн хавсралтын 10 дахь заалтын 8 дахь багана

Нийт талбайн хэмжээ-2441 м²

-----000-----